



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

"Эм Ди Эс энд ХаанЛекс" ХХН-ийг  
үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө үзүүлэх  
хуулийн этгээдээр бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.15, 24.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 451 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам"-ын 4.2, 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Өмгөөллийн "Эм Ди Эс энд ХаанЛекс" ХХН-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсүгэй.

2. Өмгөөллийн "Хаанлекс" ХХН, Өмгөөллийн "Эм Ди Эс энд Ассошэйтс" ХХН нар нь нэгдэж "Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН болсон тул "Хаанлекс" ХХН, "Эм Ди Эс энд Ассошэйтс" ХХН нарыг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийн бүртгэлээс хассугай.

3. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг Өмгөөллийн "Эм Ди Эс энд ХаанЛекс" ХХН /Ж.Майзориг/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Ю.Нэргүй/-т үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ГҮЙЦӨТГЭГЧ,  
ДЭД ДАРГА

Э.БАТБОЛД



000000